

ТӨРӨӨС ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫГДУНДГОВЬ АЙМАГТ 2018 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ /ХХААГазар/

2018.05.28

Бодлогын зорилт		Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хэрэгжүүлсэн үр дүн	Хувь
Нэг. Мал аж ахуйн үйлдвэрлэл, түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт.				
1.1	Малын тоо, төрөл, сүргийн бүтцийн зохистой харьцааг баримтлах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох эрсдэл даах чадавхийг бэхжүүлэх	1. Малд үзлэг ангилалт хийх, цөм сүрэг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах.	Аймгийн засаг дарга, ХХААХҮСайдтай 2018 онд хамтран ажиллах гэрээний 9-р заалт, МЭҮГазрын даргын А/18-тоот тушаалын дагуу Хулд сумын 2000 тэмээ, Өндөршил сумын 2500 адуунд үзлэг ангилалтыг хийж гүйцэтгэсэн. Одоо Сайнцагаан сумын хонин сүрэгт үзлэг ангилалтыг хийж гүйцэтгэнэ.	70.0
		2.Малыг ялган тэмдэглэх, бүртгэлжүүлэх ажлыг эрчимжүүлэх, гарал үүслийг баталгаажуулах суурь нөхцөлийг бүрдүүлэх.	Нийт 109000 мянган мал байгаагаас 90000 мянган малыг хувийн дугаартай болгож бүртгэл мэдээллийн сан сүлжээнд хамруулаад байна. Ингэснээр гарал үүсэл нь тодорхой болох нөхцөл бүрдэнэ.	70.0
		3.Үхэр сүргийн тоо толгой, нийт малд эзлэх хэмжээ, ашиг шимийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн аймгийн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ	Хугацаа болоогүй	-
1.2	Бог малын хээлтүүлэгчийг мэргэжлийн байгууллагын хяналтанд авч үржлийн ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулах.	1. Бог малын хээлтүүлэгчийг хээлтүүлгийн бус үед эх сүргээс нь ялгах ажлыг зохион байгуулж мэргэжлийн байгууллага, мэргэжилтний мэдэлд авах	Бог малын хээлтүүлэгчийг Говь-Угтаал сум, Хулд сумдын МҮҮНэгжүүд ялган суурилоод байна. Гэсэн хэдий ч бог малын хээлтүүлэгчийг хээлтүүлгийн бус үед эх сүргээс нь ялгах ажил орон нутагт 50 орчим хувьтай явагдаж байна.	40.0
		2. Мал үржүүлэг технологийн мэргэжлийн ажил үйлчилгээ үзүүлэх хувийн хэвшлийн нэгжийг сумдад байгуулах, бодлогоор дэмжих	Хугацаа болоогүй	-
1.3	Эрчимжсэн аж ахуйг хөгжүүлж төв суурин газрын сүү, махны хэрэгцээг хангах	1. Сүүний чиглэлийн үхрийн аж ахуй хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.	Аймгийн хэмжээнд 45 өрх 527 сүүний үхэртэйгээр үйл ажиллагаа явуулж байна. ХХААГазрын дарга, сумдын засаг даргын 2018 оны үр дүнгийн гэрээнд тус заалтын талаар тусган бодлогоор нэмэгдүүлэх боломжийг ханган ажиллаж байна.	40.0
		2.Туслах аж ахуйг хөгжүүлэх /Гахай, тахиа/ г.м	Аймгийн хэмжээнд 1 аж ахуйн нэгж, 14 өрхийн 274 гахай, 11 өрхийн 621 тахитай үйл ажиллагаа явагдаж байгаа. ХХААГазрын дарга, сумдын засаг даргын 2018 оны үр дүнгийн гэрээнд тус заалтын талаар тусган бодлогоор нэмэгдүүлэх боломжийг ханган ажиллаж байна.	40.0
		3. Тэмээ өсгөх хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллах,	Хөтөлбөрийн 2018 онд хэрэгжүүлэх 9 заалт үйл ажиллагааны төлөвлөгөөг гарган хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	40.0

		цаашид тэмээний аж ахуйг дэмжиж, тоо толгойг нэмэгдүүлэх.		
		4. Эрчимжсэн аж ахуй хөгжүүлэх тал дээр иргэд аж ахуйн нэгжид хөнгөлөлттэй зээл олгох, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх	Хугацаа болоогүй	-
1.4	Бэлчээр болон байгалийн нөөцийн зохистой ашиглалт, бэлчээрийн газар зохион байгуулалт, төлөвлөлт, отрын бүс нутгийн нөөц бэлчээрийг нэмэгдүүлэх	1.Бэлчээр болон байгалийн бусад нөөцийн зохистой ашиглалтыг сайжруулах	<p>Бэлчээрийн хортон мэрэгч үлийн цагаан оготнойтой нийт 72,5 мян/га талбайд энгийн механик болон микробиологийн аргаар тэмцэх ажлыг зохион байгуулахаас Өвөрхангай, Төв аймгийн хил залгаа 7 сумыг хамруулан /Эрдэнэдалай, Адаацаг, Дэрэн, Цагаандэлгэр, Сайнцагаан, Дэлгэрцогт, Луус/ 22,5 мян/га талбайд бактержуулсан бэлдмэл цацаж микробиологийн аргаар тэмцсэн. Санхүүжилтийг аймгийн ОНХС-ийн 36,3 төгрөгөөр хөрөнгөөр 10 тн бактержуулсан бэлдмэлийг “ШИМ” ххк –тай гэрээ байгуулан сумдад нийлүүлсэн.</p> <p>Мал услах ундны ус байхгүйгээс ашиглагдахгүй байгаа бэлчээрийг ашиглах зорилгоор нийт 17 гүн өрмийн худгийг улсын төсвийн хөрөнгө оруулалт болон бусад эх үүсвэрээр гаргана. ХХААХҮЯ-нд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар гаргах 6 худгийн тендер зарлагдан гүйцэтгэгч компани шалгараад байна. Худгийн өрөмдлөгийн машиныг гэрээгээр эзэмшигч Элбэгсанчир ХХК нь 2016-2017 оны ажлаа дүгнүүлэн, 2018 онд гүйцэтгэх гэрээг байгуулан ажил эхлээд байна</p> <p>Бэлчээрийг зөв зохистой ашиглах бэлчээрийн маргааныг зохицуулах зорилгоор аймаг сумдын бэлчээр ашиглагчдын холбооны үйл ажиллагааг эхлүүлэх өргөжүүлэх, дэмжиж хамтран ажиллах. Аймгийн бэлчээр ашиглагчдын холбоо байгуулагдан АБАХ-ын тэргүүнээр Ё.Дашням сонгогдсон. Төсөлд хамрагдсан сум бүрт СБАХ-ууд байгуулагдан үйл ажиллагаа эхлээд байна. Ногоон Алт-Малын эрүүл мэнд төслийн хүрээнд 5 суманд 17 БАХ байгуулагдан, БАХ-д өөрийн хэсгүүдийн бэлчээрийн зааг, зах хязгаарыг газрын зурагт тусган хэрэгжүүлж эхлээд байна.</p> <p>Малчдад бэлчээрийг хуваарьтайгаар ашиглах болон нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэхэд тэдний оролцоо, чадавхижуулах чиглэлээр Луус, Адаацаг сумдын Малчдын зөвлөгөөнд нийт 228 малчинд сургалт зохион байгуулсан. 05 сарын 28-31 хооронд Адаацаг сумын БИНХ-ын өдөрлөгүүдээр чадавхижуулах сургалтуудыг хийж байна.</p>	40.0
		2.Бэлчээрийн газар зохион байгуулалт, төлөвлөлт, удирдлагын тогтолцоог сайжруулах	Аймгийн хэмжээний газар зохион байгуулалтын төлөвлөгөөг аймаг ОНХС-ийн хөрөнгөөр хийхээр болсон ба түүний салшгүй нэг хэсэг нь бэлчээрийн төлөвлөлт зохион байгуулалт тусгагдан хийгдэхээр болоод байна.	0.0
		3.Отрын бүс нутаг шинээр тогтоож, сумын ИТХурлаар хэлэлцүүлэн батлуулж, кадастрын нэгдмэл санд бүртгүүлэх баталгаажуулах ажлыг зохион	Дундговь аймаг нь нийт 7114.5 мян/га бэлчээрийн талбайтай бөгөөд аймгийн хэмжээнд нийт 9 сум, сумын ИТХ-ын шийдвэрээр 674,2 мян/га нутаг дэвсгэрийг отрын бүс нутгаар тогтоосон. Аймгийн ИТХ-ын тогтоолоор 200,0 га бэлчээрийг адууны отрын бүс нутаг, аймаг дундын отрын нөөц нутгаар Дэлгэрхангай, Сайхан-Овоо, Эрдэнэдалай сумын	40.0

		байгуулах	зааг Дундын нуруу орчмын нутаг 5651,1 мян/га бэлчээрийг сум дундын отрын нөөц нутгаар шинэчлэн тогтоосон. Нийт 879,8 мян га бэлчээрийн талбайг отрын бүс нутгаар тогтож 12 хувийг тусгай хамгаалалтанд авсан. Цаашид боломжит сумдуудыг отрын бүс нутгийг шинээр тогтоох болон нэмж авах тухай албан тоотыг сумдад хүргэсэн.	
1.5	Бэлчээрийндаац, төлөвбайдлынүнэлгээндтулгуурланмалынтоо, төрөл, сүргийнбүтцийгтохируулах, бэлчээрийгоновчтойашиглах, хамгаалах, нөхөнсэргээх	1.Бэлчээрийн төлөв байдлын судалгааг жил бүр гарган, малын тоо толгойн өсөлт, сүргийн бүтцийг тооцоолох.	Хугацаа болоогүй.	-
		2.Бэлчээрийг оновчтой ашиглах, хамгаалах,нөхөн сэргээх арга хэмжээг орон нутгийн төсөвтэй уялдуулан зохион байгуулах	Аймгийн бэлчээр ашиглагчдын холбоо байгуулагдан тэргүүнээр Ё.Дашням сонгогдсон. Төсөлд хамрагдсан сум бүрт СБАХ-ууд байгуулагдан үйл ажиллагаа эхлээд байна. Ногоон Алт-Малын эрүүл мэнд төслийн хүрээнд 5 суманд 17 БАХ байгуулагдан үйл ажиллагаагаа эхлээд байна. БАХ-д өөрийн хэсгүүдийн бэлчээрийн зааг, зах хязгаарыг газрын зурагт тусган хэрэгжүүлэхээр болоод байна.	40.0
1.6	Бэлчээрийнургамалдхөнөөлучруулжбайгаамэрэгчамьтан, шавжтайтэмцэхаргахэмжээгбайгальорчиндхалгүй, дэвшилтэттаргатехнологиашиглан явуулах	1. Бэлчээрийн хөнөөлт үлийн цагаан оготно болон шавжтай тэмцэх ажлыг үргэлжлүүлэх, үр дүн хяналтыг сайжруулах	Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн яам, Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнтэй 2018 онд “Бэлчээрийн ургамалд хөнөөл учруулж буй мэрэгч амьтан, царцааны тархалт, хөнөөлийн тодотгох судалгаа хийлгэх тухай” хамтран ажиллах гэрээний дагуу бэлчээрийн хөнөөлт мэрэгчдийн тархалт, олшролыг тодотгох судалдгааны ажлыг хүрээлэнгийн судлаачид тус аймгийн 7 суманд хийж гүйцэтгэсэн. Судалгааны дүнгээр бэлчээрийн хөнөөлт мэрэгч болох цайвар үлийчийн голомт бүх сумдад тархсан нягтрал хэт олшролын шатандаа орсон энэ үед бэлчээрийн ургамлын 40-өөс дээш хувийг хөнөөдөг байна. Иймээс механик биологийн аргыг микробиологийн аргатай хослон хэрэглэх шаардлагатай байна гэж үзсэн. 2018 онд сумдаас ирүүлсэн судалгаагаар нийт нутаг дэвсгэрийн 17.8 хувь буюу 12 сумын 1503402 га бэлчээрийн талбайд үлийн цагаан оготно тархалттай байна гэсэн судалгаа гарсан. ХХААХҮЯ-ны төрийн нарийн бичгийн даргын тушаал гарч Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 50,0 мян/ га бэлчээрийн талбайд энгийн механик аргаар тэмцэх шийдвэр гаргасны дагуу аймгийн Засаг даргын захирамж гарч үлийн цагаан оготны голомт бүхий 8 сумын 72,5 мян/га талбайд тэмцэх ажлыг энгийн механик болон микробиологийн аргаар тэмцэж эхлээд байна. Энэ ажлын хүрээнд аймгийн ОНХСанд тусгасан 36,3 сая төгрөгөөр 10 тн бактержуулсан бэлдмэлийг “ШИМ” ХХК –тай гэрээ байгуулан аймгийн ХХААГ-т хүлээн авч оготны голомт бүхий Өвөрхангай, Төв аймгийн хил залгаа 7 сумын ХАА мэргэжилтэн, байгал орчны байцаагч, багийн засаг дарга, малчин нийт 47 хүнд энгийн механик аргаар хэрхэн тэмцэх болон микробиологийн бэлдмэлийг хэрэглэх, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг мөрдөх талаарх чиглэл мэдээллийг өгсөн. Мөн сумдад хяналт тавьж үйл ажиллагааг орон даяар сурталчлан танилцуулсан. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 50,0	70.0

			мян/га бэлчээрийн талбайд энгийн механик аргаар тэмцэх ажлын хүрээнд цөмлөгч-15ш, утагч-40ш багажийг захиалан авчирч сумдад олгосон.	
1.7	Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах	1. Аймаг сум орон нутгийн ОНХС-ийн хөрөнгө, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар гүн өрмийн худаг уст, цэг шинээр гаргах болон сэргээн засварлах	Энэ онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 6 гүн өрмийн худгийг нэр бүхий 6 суманд, худгийн өрөмдлөгийн машиныг гэрээгээр эзэмшигч Элбэгсанчир ХХК нь 10 суманд 11 гүн өрмийн худгийг гаргах гэрээг байгуулаад ажил эхэлж байна. 2018 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 17 худаг гаргана. Сумдууд энгийн уурхайн худгуудыг ОНХСийн хөрөнгөөр сэргээн засварлана.	40.0
		2. Хөв, цөөрөм байгуулах, булгийн эхийг хашиж хамгаалах, гар худаг гаргах	Сумдууд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр энгийн уурхайн худгуудыг сэргээн засварлана.	0.0
		3. Тэжээлийн нэг ба олон наст ургамал тариалсан иргэдийг дэмжих, Дэрэн сумын тэжээлийн үйлдвэрийн үйл ажиллагааг өргөжүүлэн ажиллуулах.	Дэрэн сумын тэжээлийн үйлдвэрийн үйл ажиллагааг дэмжин улсын хөрөнгө оруулалтаар 1 гүн өрмийн худгийг тариалалтын талбайг түшиглэн гаргахаар аймгаас шийдвэрлсэн.	40.0
1.8	Мал аж ахуйн эрсдлийг бууруулах, чадавхи бий болгох /Мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах, уялдаа холбоог сайжруулах/	1.Байгалийн гамшигт үзэгдэл болон урьдчилан сэргийлэх мэдээллийг цаг тухай бүр малчид, иргэдэд хүргэх арга хэмжээг шат, шатны байгууллагуудыг хамруулан зохион байгуулах 2.Цаг агаарын аюулт үзэгдлийн давтамж, байгалийн эрсдэл ихтэй бүсийн сумдад цаг агаарын гэнэтийн аюулыг тандах, мэдээлэх, урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээ АСЦ-ийг үр дүнтэй ашиглах.	Аймгийн цаг уурын албанаас цаг агаарын мэдээг 7 хоногоор болон сарын тойм мэдээллийг гаргаж малчид, иргэдэд хүргэдэг. Цаг агаарын гамшигт аюултай үзэгдлийн талаархи урьдчилан сэргийлэх мэдээ зарлагдсан үед онцгой байдлын ерөнхий газраас зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллаж байна.	70.0
2	Хоёр. Тариалангийн үйлдвэрлэл түүхий эд бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт			
2.1	Төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний тариалалтанд ус эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд халгүй дуслын болон намираа, бороожуулагч усалгааны дэвшилтэд технологийг нэвтрүүлэх	1.Төмс, хүнснийногоо, жимсжимсгэнийтариалалтандзори улсаннамираа, дуслынусалгаа, бороожуулагчтоногтөхөөрөмжолго хөддэмжлэгүзүүлэх, бага, дунд хүчин чадалтай техник, тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулах.	Хугацаа болоогүй	-
2.2	Усны хайгуулын судалгаанд тулгуурлан гадаргын болон бороо цасны усыг хуримтлуулах, усалтын	1.Онгиголыгтүшиглэнусалгаатайга зартариалангийн /төмс, хүнснийногоо, чацаргана/ ажахуйбайгуулахыгдэмжих	Аймгийн Засаг дарга Сайхан-Овоо сумын Засаг дарга	-

	системийн сайжруулах, тариалангийн хэмжээг нэмэгдүүлэх	ашиглалтыг усалгаатай талбайн талбайн		
2.3	Жимс, жимсгэний тариалалт, нэртөрлийг нэмэгдүүлэх	1. Дэрэн, Дэлгэрцогт суман дахь Эрдэм шинжилгээ, туршилт, үйлчилгээ ОНӨААТҮГазрын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтарч ажиллах	Хугацаа болоогүй	-
		2. Жимс, жимсгэний аж ахуй байгуулахад урт хугацаатай зээлийн дэмжлэг үзүүлж, баталгаат сортын суулгацын тариалалтыг 100 га-гад талбайд хүрэх	Хугацаа болоогүй	-
		3. Чацаргана болон ороннутаг тургах боломжтой жимс, жимсгэний суулгац үржүүлгийн план тацыг байгуулах, баталгаат сортын суулгацаар тасралтгүй хангах, зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэх	Хугацаа болоогүй	-
2.4	Өвөл, зуны хүлэмжийн болон зоорийн ажахуйг хөгжүүлэн хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлж, хотсуурингийн хүнамыг жилийн турш шинэ ургацын ногоо ортогтвортой хангах	1. Өвлийн нарлаг хүлэмжийн үйл ажиллагааг жигдрүүлэх менежментийг сайжруулах	Өвлийн нарлаг хүлэмжинд “Хүрээн-Ус” хоршоо нь 600 м.кв талбайд тариалалтын ажлыг эхлүүлсэн. Хүлэмжийг байнгын ажиллагаанд оруулах шаардлагатайгаас гадна цахилгаан, цэвэр усны хангамжийн хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх шатандаа явж байна	40.0
		2. Хүлэмжийн ажахуй байгуулахад дот оод, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжин, урт хугацаатай зээлийн дэмжлэг үзүүлэн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх /10 гаталбай бүхий хүлэмж байгуулах/	Арилжааны банк, ОУБ, ААН	-
		3. Төмс, хүнсний ногооны хадгалалт борлуулалтын сүлжээг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, ороннутаг зоорийн ажахуйг хөгжүүлэх	Арилжааны банк, ОУБ, ААН	-
3	Гурав. Хүнсний аюулгүй байдал, боловсруулах үйлдвэрлэл			
4.	Эрүүл аюулгүй, тэжээллэг хүнсээр хүнамыг жигд хүртээмжтэй хангах,	1. “Дундговийн мах”, “Дундговийн айраг” брэндийг баталгаажуулж, экспортыг дэмжиж, Улаанбаатар	“Их хайрхан мандал” ХХК нь Улаанбаатар хотын хэрэглэгчдэд Дундговийн махыг 2016 оноос хойш Нисэх, Яармаг зэрэг газруудад 2 худалдааны цэгээр нийлүүлж үйл ажиллагаагаа явуулж байна.	100.0

	хүнсний боловсруулах үйлдвэр лэлийн түүхий эдийн бэлтгэнний лүүлэлтийн улирлын хамаарлы гбууруулах, импортлох хүнсний үйлдвэрлэлийг дэмжих	хотод худалдааны цэгтэй болно.		
		2. Сум бүр нядалгааны цэгтэй болж улмаар хүнсний захуудад орон тооны малын эмчийг тогтмол ажиллуулан эрүүл ахуй шаардлагад нийцсэн махаар хүн амын хэрэгцээг хангана.	Сайнцагаан, Говь-угтаал, Адаацаг, Өндөршил суманд уламжлалт аргаар мал төхөөрөх цэг ажиллаж иргэд ААНэгжид үйлчилж байна. Сайнцагаан сумын Тогтох Мандал ХХК-ын хүнсний захад малын эмч ажиллаж хүнсний захгаар худалдаалж буй малын маханд хяналт тавин ариун цэвэр эрүүл ахуйд нийцсэн махыг нийлүүлж байна.	100.0
		3. Үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан мах, сүүн бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх	Үйлдвэрийн аргаар боловсруулсан мах, сүүн бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх бодлогын хүрээнд Өлзийт суманд дулааны аргаар хуурай сүү боловсруулах үйлдвэр, Сайнцагаан суманд Ноён Шанхай ХХК нь мал төхөөрч мах, махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрүүдийг тус тус байгуулах иргэн, ААНэгжүүдийг дэмжин ажиллаж байна.	100.0
		4. Хүнсний эрүүл мэндэд хорхөнөөлгүй, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн, байгаль орчиндээлтэй, зориулалтын хүнсний сав, баглаа боодол, хаягшошгыг хүнсний сүлжээний бүхү ешатанд хэрэглэх, үйлдвэрлэлийг дэмжих	Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа нийтийн хоол, хүнсний үйлдвэрлэл, сургууль, цэцэрлэг, иргэдэд хүний эрүүл мэндэд хортой зориулалтын бус савны талаар зөвлөмж зөвлөгөөг өгч гарын авлага материалаар ханган ажиллаж байна. Сургууль цэцэрлэгүүд нь 100 хувь хүнсний зориулалтын сав, тоног төхөөрөмжийг өдөр тутмын үйл ажиллагаанд хэрэглэж хэвшсэн байна. Мөн нийтийн хоол, хүнсний үйлдвэр, цехийн 85-90 хувь хүнсний зориулалтын сав ашиглаж байна. Сум хөгжлийн сангаас хүний эрүүл мэндэд хорхөнөөлгүй эрүүл ахуйн шаардлагад нийцсэн хүнсний сав баглаа боодол, цаасан уут үйлдвэрлэх хүсэлтэй 2 иргэний төсөлд нийт 40 сая төгрөгийн санхүүжилтийн дэмжлэг үзүүлсний үр дүнд 5-6 нэр төрлийн, нийт 15500 ш хүний эрүүл мэнд байгаль орчинд сөрөг нөлөөгүй цаасан тор уутыг үйлдвэрлэж зах зээлд нийлүүлж эхлээд байна. Сайнцагаан сумын ТЭББЭ ХХК нь 2013 онд СХСангийн зээлд хамрагдан уламжлалт модон хувин савны үйлдвэрлэл амжилттай явуулж байна. Энэхүү үйлдвэрлэлийг эрхэлснээр орон нутаг төдийгүй бүс нутгийн хэрэглэгчдийн талархалыг хүлээсэн бүтээгдэхүүний нэг болоод байна.	100.0
	5. Аймгийн төвд стандартын шаардлага хангасан худалдааны төв байгуулж, хүнсний бүтээгдэхүүнд хяналт үнэлгээ хийх дотоодын лабораторитой болж эрүүл ахуйн шаардлага хангасан бүтээгдэхүүнээр иргэдийг хангана.	“Худалдааны салбарыг хөгжүүлэх бодлого”-ын хүрээнд аймгийн төвд орчин үеийн шаардлага хангасан иргэдийн хэрэгцээт чанартай бараа бүтээгдэхүүнийг худалдаалах, ажлын байр, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор худалдааны төв байгуулах төслийг ажлын хэсгээр боловсруулж Засаг даргын Зөвлөлийн хурал болон ИТХ-аар хэлэлцүүлэн ажиллаж байна.	40.0	
4	Дөрөв. Жижиг дунд үйлдвэрлэл			
4.1	Орон нутгийн үйлдвэрлэлийг хамгаалж, түүхий эдийг дотооддоо боловсруулж, дэвшилтэт техник, технологийг гнутагшуулан экспор	1. Төрийн болон орон нутгийн нөмчийн хөрөнгөөр хийх худалдан авалтад тоодын үйлдвэрийн бүтээгдэхүүнийг тэргүүнээлжин дхамруулах тогтолцоог бий болгож, хэрэгжүүлэх	Зээлийн батлан даалтын сангаас ирүүлсэн албан тоот, төлөвлөгөөг үндэслэн үйл ажиллагааг зохион байгуулж байна. 4 удаагийн хурал, зөвлөгөөнд нийт 183 иргэнд ЗБДСангийн мэдээллийг хүргэж ажилласан. Өмнөх онуудад тус аймгаас зээлийн батлан даалтын санд 5 бизнес эрхлэгч зээлтэй байгаа үүнээс 4 бизнес эрхлэгч буюу Дэлгэрэх бүрд ХХК,	70.0

	ртыгдэмжих, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, өрсөлдөх чадвар бүхий үйлдвэрлэл, үйлчилгээг бий болгох		Мандал Шилтгээн ХХК, М.Цэрэнпагма, Д.Баясгалан нарын үйл ажиллагаатай танилцан мониторинг хийсэн. 2018 оны 2 дугаар улиралд Зээлийн батлан даалтын санд 3 бизнес эрхлэгчийн анхан шатны хүсэлтийг явуулаад байна.	
		2. Зээлийн батландаалт болон хөрөнгийн барьцааны эрх зүйн орчныг болговсронгуй болгох замаар үйлдвэрлэл эрхлэгчдийн санхүүжилтийн боломжийг нэмэгдүүлэх	СХСангаас Эрдэнэдалай сумын 14 бизнес эрхлэгчдэд 86,5 сая төгрөгний хөнгөлөлттэй зээлийг олгосон. Үүний үр дүнд бүтээгдэхүүний нэр төрөл 3-4 төрлөөр нэмэгдсэн байна. Нийт 14 ажлын байр бий шинээр бий болсон байна.	100.0
		3. Үйлдвэрлэл, технологийн инкубаторийг хөгжүүлэх замаар гарааны компаниудын үйл ажиллагааг дэмжих	Энэ чиглэлийн төслийн санхүүжилт олгогдоогүй байна.	-
4.2	Орон нутгийн нөөц бололцоо, сумдын онцлогт тохирсон хөнгөн, жижиг дунд үйлдвэрийг байгуулах иргэдийн санал санаачлагыг дэмжих	1. Мандалговь хотод барилгын төмөр бетон /хучилтын хавтан, ялуу, суурийн гулдмай, замын хашлагагм/-ын үйлдвэр байгуулах санаачлагыг дэмжих	Дэлгэрэх бүрд ХХК нь Жайка ОУБ-с 800,0 сая төгрөгний санхүүжилтийг авч 2018 оны 10 сард үйл ажиллагаа нь эхлэх төлөвлөгөөтэй байна. Зайрмагтай булаг ХХК нь 2017 оны 12 сараас эхлэн "ROYAL" зочид буудал, зоогийн газрын үйл ажиллагааг явуулж эхэлсэн. "ROYAL" зочид буудал зоогийн газарын 150 иргэний сургалт явуулах боломжтой сургалтын танхим, зочид буудлын 16 өрөөг тохижуулах төслийг ЖДҮХ Сангийн бодлогын зээлд хамруулахаар хүргүүлээд байна.	70.0
		2. Аймгийн төвд өндөр зэрэглэлийн зочид буудал, зоогийн газар байгуулах санаачлагыг дэмжих	ХОХБТХ	-
		3. Хөдөө явуулынахуйн үйлчилгээг нэвтрүүлэх санаачлагыг дэмжих	Эрдэнэдалай, Хулд сумын СХСангаас Малын гаралтай түүхий эд боловсруулах цех байгуулахаар ирүүлсэн 4 иргэний төслийг 23,0 сая төгрөгөөр тус тус дэмжсэн. Шинээр 5 ажлын байр бий болж 1 ажлын байр хадгалагдсан байна.	100.0
		4. Сум бүрт мал нядалгааны болон ар ьсширний анхан шатны тордолт хийх цех байгуулах санаачлагыг дэмжих	Аймгийн ЗДТГ Сумын Засаг дарга нар	-
Дундаж				63,4%

Төлөвлөгөөний хэрэгжилт нэгтгэсэн: Мэргэжилтэн:.....Л.Нарантуяа

